

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН VI ИХ НААДАМД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО.

Монголын хүүхдийн спортын VI их наадам 2019 оны 09 дүгээр сарын 07-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Тус наадамд 21 аймаг, 9 дүүргийн 4588 тамирчид оролцож үндсэн төрөлд спортын 19, сонгох 5, паралимп 4, дифлимп 2, тусгай 3 төрлөөр тус тус өрсөлдлөө.

Наадамд манай аймгаас спортын 16 төрлөөр 165 тамирчин, 22 дасгалжуулагч оролцож хүндийн өргөлт 5 алт, 4 мөнгө, 1 хүрэл, чөлөөт бөх 1 алт, 1 хүрэл, даам 1 алт, таеквондо 2 мөнгө, 2 хүрэл, жүдо бөх 1 мөнгө, бокс 1 мөнгө, хөнгөн атлетик 2 хүрэл, самбо бөх 1 хүрэл, спорт бүжиг 2 мөнгө, тусгай олимп 1 алт, 1 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 7-р байр эзэллээ.

Их наадмын хамгийн зохион байгуулалт сайтай 6 аймгийн нэгээр шалгарч цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.



Монголын хүүхдийн спортын VI их наадамд оролцох баг тамирчдыг амйгийн Засаг дарга хүлээн авч тэмцээнд нь амжилт хүслээ.



Хүндийн өргөлтийн баг тамирчид



Таеквондогийн баг тамирчид



Хөнгөн атлетикийн баг тамирчид



Чөлөөт бөхийн баг тамирчид



Спорт бүжгийн баг тамирчид



Ширээний теннисний баг тамирчид

ОРОН НУТАГТАА УЛСЫН ЧАНАРТАЙ УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТОВЧ ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Аймаг орон нутагтаа их спортыг хөгжүүлэх, тамирчдын амжилт, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор ширээний теннисний насанд хүрэгчид, хүндийн өргөлтийн залуучууд, спорт бүжгийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг Арвайхээр сумандаа зохион байгуулсан.

1. Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонт, Спортын мастер Т.Мэргэн багшийн нэрэмжит 2019 оны Монгол улсын аварга шалгаруулах ширээний теннисний насанд хүрэгчдийн тэмцээнийг 04 дүгээр сарын 04-06-ны өдрүүдэд Арвайхээр суманд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 20 байгууллагын 23 багийн 181 тамирчин оролцож дүнгээ гаргаж багийн нэгдсэн дүнгээр: ТЭРГҮҮН байрыг Я.Баярсайхан дасгалжуулагчтай “Өсөх зоос” баг, ДЭД байрыг Э.Мөнхбилэг дасгалжуулагчтай “Цэц шагай” баг ГУТГААР байрыг Ч.Нямаа дасгалжуулагчтай Орхон аймгийн баг тус тус шалгарч медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.



2. Спортын мастер П.Дуламдорж агсны нэрэмжит 2019 оны Хүндийн өргөлтийн насанд хүрэгчдийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 04 дүгээр сарын 06-07-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгууллаа. Тус тэмцээнд хот, хөдөөгийн 16 байгууллагын 105 тамирчин оролцож хурд хүчээ сорин өрсөлдлөө. Манай аймгийн баг тамирчид 11 алт, 15 мөнгө, 14 хүрэл нийт 40 медаль хүртэж А.Дөлгөөн, Ч.Бумчин, Г.Очирбат нар жин жиндээ рекорд дээд амжилтыг шинэчлэн тогтоож Б.Лувсандамба спортын дэд мастер цолны болзол хангаж, багийн дүгнээр эмэгтэй 2 дугаар байр, эрэгтэй 1 дүгээр байрыг тус тус эзэллээ.



3. Таеквондогийн өсвөр үе, бага насны улсын аварга шалгаруулах тэмцээнийг 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд Арвайхээр суманд зохион байгуулсан. Тэмцээнд 32 байгууллагын 642 тамирчин оролцсноос манай аймгийн баг тамирчид алт 11, мөнгө 8, хүрэл 6 нийт 25 медаль хүртэж багийн П.Ээбум дасгалжуулагчтай баг 1 дүгээр байр эзэлж медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.



4. Монголын спорт бүжгийн холбооны 2019 оны Залуучуудын латин бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээн Арвайхээр хотноо амжилттай зохион байгуулсан.

СПОРТЫН АЛБА

ТИВ, ДЭЛХИЙ, ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН

Өвөрхангай аймгийн тамирчид 2019 онд тив, дэлхий, олон улсын тэмцээнд 11 удаа, 29 тамирчин оролцож 14 медаль хүртсэн.

Үүнд:

1. Хонгконг улсад зохион байгуулагдсан жүдо бөхийн Азийн нээлттэй тэмцээнд Б.Очир дасгалжуулагчтай 2 тамирчин оролцож алт, хүрэл медаль хүртэж Казакстаны Алматы хотод өсвөрийн Дэлхий аварга шалгаруулах тэмцээнд оролцож 50кг Мэндсайхан, 55кг Х.Батцэнгэл нар шагналт 7-р байрт орлоо.



2. Бүгд найрамдах Кипр улсад зохион байгуулагдсан мастеруудын хүндийн өргөлтийн ОУ-ын INTERNATIONAL OPEN тэмцээний М50 насны 67кг жинд Х.Чинзориг оролцож аварга болсон.



3. Узбек улсын Ташкент хотод зохион байгуулагдсан самбо бөхийн залуучуудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс М.Гантулга мөнгөн медаль хүртлээ



5. Зүүн Өмнөд Азийн Малайз Улсын Куала Лумпур хотод зохион байгуулагдсан мэргэжлийн Бочигийн спортын өсвөрийн Ази тивийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн 6 тамирчин оролцож 2-р сургуулийн дэргэдэх тусгай бүлгийн ангийн суралцагч Н.Бат-Эрдэнэ мөнгөн медаль, Т.Намжилмаа ганцаарчилсан төрлөөс хүрэл медаль хүртлээ



6. Хэвтээ шахалтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн Монгол улсад зохион байгуулагдлаа. Тэмцээнд Д.Мөнхсүлд дасгалжуулагчтай 3 тамирчин оролцож М3 ангилалд С.Богд-Очир 66кг-ын жинд алт, М2 ангилалд Б.Баярсайхан мөнгө, өсвөрийн 59кг-ын жинд Л.Отгон-Эрдэнэ мөнгө, хүрэл медаль хүртсэн.



